

Мал эмнэлгийн газар

1932-8-5 нд Сайд нарын Зөвлөлийн 7-р тогтоолын 11-р зүйлээр Улаанбаатар аймгийн захиргааны зохион байгуулалтыг

- 3-5 хүнтэй тэргүүлэгчид
- малын ажил ба хадлан тариалангийн хэлтэс
- цэргийн хэлтэс
- санхүүгийн хэлтэс
- ардыг гэгээрүүлэх хэлтэс
- хотын аж ахуйн хэлтэс
- бичиг дансны ангитайгаар баталжээ.

1932 онд Сайд нарын Зөвлөлөөс гаргасан тогтоол /хагас/-д дурьдахдаа хүний урьд Сайд нарын Зөвлөлөөс Улаанбаатар хотын захиргааг аж ахуйн талаар биеэ даасан газар болгож ялган байгуулах тухай гаргасан тогтоолд нэмэгдүүлэн тогтоосон.

1937-4-23-нд Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хурлын 4-р зүйлээр Нийслэл Улаанбаатар хотыг захирах яамны дүрмийг баталжээ.

Мөн яам нь Сайд нарын /Зөвлөлийн гишүүн байна гээд дотоод байгуулалтыг /

- - Хотын байдлыг сайжруулах хэлтэс, энэ хэлтэст харьяалагдах
- - Орон сууцны тасаг
- - Түлээ модны бэлтгэлийн газар
- - Захирах тушаах хэлтэс
- - Санхүүгийн хэлтэс
- - Цэргийн хэлтэс
- - Ардын соёл боловсруулах хэлтэстэй байна гэжээ.

Мөн яамны шууд захиргааны газрууд:

- - Амгаланбаатар хотын захиргаа
- - Хороо, хоридын захиргаад
- - Хотын өнчин ядуусыг тэтгэх газар
- - Хүн эмнэлгийн салбар газрууд

Тусгай дүрмээр хотын хэмжээнд дээр ажиллах газрууд

- - Хотын прокурорууд
- - Хотын шүүх таслах газар
- - Хотын хоршооны байгууллагууд
- - Барьцаалан зээлдүүлэх ламфортын газар
- - Хотын доторхи артель, нэгдэл, үйлдвэр, мал эмнэлгийн ажил явуулах удирдлага нөлөөг үзүүлнэ гэжээ. \

1972-6-16-нд Сайд нарын Зөвлөлийн 232-р тогтоолоор 1972-7-1-нэс эхлэн Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд хөдөө аж ахуйн хэлтэс байгуулж орон тоог хэлтсийн дарга 1, мэргэлтэн 4, ня-бо 1, бүгд 6 нэгчээр тогтоогоод тус хэлтсэд **шувуун** фабрик, гахайн завод, амгалангийн сангийн аж ахуй, хотын мал эмнэлэг, нэгдлийн захын конторыг харьяалуулжээ.

1977-1-6-нд Намын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 5-р тогтоолоор Улаанбаатар хотод мал эмнэлгийн газар байгуулан ажиллуулахаар тогтоожээ

- 1977 оны 12-25-ны байдлаар Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьяа газар, байгууллага нь:
 - 1. Нэгдлийн захын контор
 - 2. Улаанбаатар хотын барилга- архитектурын газар
 - 3. Хот цэцэрлэгжүүлэхтрест
 - 4. Усны аж ахуй, ашиглалтыг удирдах газар
 - 5. Гэрэлтүүлэг, чимэглэлийн үйлдвэр
 - 6. Кино контор
 - 7. Гэрлэх ёслолын ордон
 - 8. Улаанбаатар хотынбарилга засварын нэгдсэн трест
 - 9. Хотын мал эмнэлгийн газар
 - 10. Гачууртын сангийн аж ахуй
 - 11. Партизаны сангийн аж ахуй
 - 12. Шувуу фабрик
 - 13. Гахай бордох завод
 - 14. Ногооны комбинат
 - 15. Хүнсний барааны өөртөө үйлчлэх их дэлгүүр /универсам/ тус тус байжээ.